

Нэгж сэдэв: Монгол ардын аман яруу найраг

Ээлжит хичээлийн сэдэв: Хэл зүгшрүүлэх үг

Ээлжит хичээлийн зорилго: Хэл зүгшрүүлэх үгийн үүрэг, хэлний хэрэглээг ойлгох, хэрэглэх



Дараах асуултад хариулаарай.



- Та нар жаахан байхдаа ямар ямар авиаг хэлж чаддаггүй байсан бэ?
- Тэр үсгүүдээ яаж дууддаг байсан бэ?



Монголчуудын хүүхдийн хэл яриаг хөгжүүлдэг уламжлалаас уншаарай.

- Аман наадам Монголын ард түмэн мянга мянган жил хуримтлуулсан ахуй амьдрал соёл хүмүүжлийн арга туршлага, эрдэм мэдлэгийн ихэнх нь малчин олны амьдрал туршлагаар баяжигдан уламжлагдаж ирсэн боловч нэгэн хэсэг нь хуучин цагийн ном сударт, зарим хэсэг нь ардын аман зохиолд ам дамжигдан үлдэж зарим нэг нь мартагддаг байна. Нэгэн нутагт боловсорсон сайн зүйлс эрдэм ухаан бүх ард түмний хүртээл болж чадахгүй байсан тул ард түмэн үүнийг эрт мэдэж, олсон ололт амжилт арга туршлага эрдэм мэдлэгийнхээ эрхэм дээжсийг нэг сонсмогц ой тойнд хоногшихуйц хэвшмэл хэллэг, толгой холбон айзам тааруулан шүлэглэсэн үгс болгон цээжлүүлэн үлдээдэг байжээ. Ийнхүү холбоо шүлгийн бадаг болгон хойч үедээ уламжлан үлдээдэг нэгэн сайхан арга бол ардын аман зохиолын нэгээхэн хэсэг нь болсон аман наадам буюу үгэн тоглоом гэж үзэж болно. Аман наадам нь монголын ард түмэн хойч үеэ сурган хүмүүжүүлж эрдэм мэдлэг олгох, хэл яриаг хөгжүүлэх, авиаг зөв тод дуудаж сургах явдалд онцгой ач холбогдол гүйцэтгэж, сурган хүмүүжүүлэх үйлсэд ихээхэн хувь нэмрээ оруулсаар ирсэн юм.
- Хүүхдийг хэлд сайн орсон наснаас нь эхлэн зугаа үг, түргэн хэллэг оньсого таалгах зэргээр тоглуулдаг бол хүүхдийг нилээд ухаан сууж аливаа учир зүйг ухааран ойлгох болсон үеэс эхэлж дунд хуруу олох, сүмбэр уул босгох, цэц булаалдах дайралцаа үг, ес хэлэлцэх, цоллох зэрэг тоглоомоор тоглуулдаг.



Хэл зүгшүүлэх үг хэлэхэд төвөгтэй байгаагийн шалтгааныг тодруулаарай.



Жолоо дардаг
Жороо халтар

Шаврыг усаар зуурна
Саврыг хусаар зорно

Арван тавны сар
Алсуур хүрээлэв үү?
Ойроор хүрээлэв үү?
Хорин тавны сар
Холуур хүрээлэв үү?
Ойроор хүрээлэв үү?

Арван таван тарган тарлан
Хар сарлагийн таргийг
Тараг биш гэж эс уугаад
Ямар арван таван тарган тарлан
Хар сарлагийн таргийг
Тараг мон гэж уух вэ?

Тараг мон гэж уух вэ?
Хар сарлагийн таргийг
Тараг биш гэж эс уугаад
Ямар арван таван тарган тарлан
Хар сарлагийн таргийг


Дараах алхмын дагуу ажиллаарай.

1. Түргэн хэл.
2. Түргэн хэлэх үед аль авиаг буруу дуудаад байгааг тодруул.
3. Тухайн авиаг буруу дуудаад байгаагийн шалтгаан нь аль авианаас болоод байгааг ол.
4. Ямар ямар авиаг ойр давтаж хэлэхэд төвөгтэй байгааг бич.



Асуултад хариулж, түргэн хэллэгийн айзам хэмнэлийг тайлбарлаарай.

- Түргэн хэллэг тус бүрийн эхний үсгүүд ижил, төсөөтэй дуудлагатай байна уу? Жишээгээр батлаарай.
- Түргэн хэллэг тус бүрийн төгсгөлийн үг, авиа ижил байна уу? Өөр байна уу? Жишээгээр батлаарай.
- Түргэн хэллэг тус бүр хэдэн мөрөөс бүтсэн байна вэ? Тоолоорой.
- Мөр тус бүр байгаа үгийн тоо тэнцүү байна уу? Өөр байна уу? Жишээгээр батлаарай.



Хэл зүгшрүүлэх үгийн тухай дэвтэртээ тэмдэглээрэй.

Хэлэхэд төвөгтэй авианууд бүхий үгийг ойр ойрхон давтаж, толгой, сүүл холбон, мөрөн дэх үгийн тоог тэнцүүлэн, шүлэглэсэн зохиосон аман зохиолын богино хэлбэрийг хэл зүгшрүүлэх үг гэнэ.

Дараах авианууд орсон үгийг ойр ойрхон давтаж шүлэглэнэ.

- Л-Р
- М-Н
- Б-В
- Ц-Ч
- Ш-С
- Ж-З
- Д-Т

Хэл зүгшрүүлэх үг нь хүүхдийн хэлийг хурц болгох, авиаг зөв тод дуудаж сургах ач холбогдолтой.



Дараах авианууд бүхий үгийг ойр ойрхон давтаж, түргэн хэллэг З-ыг зохиогоорой.

- Л-Р
- М-Н
- Б-В

- Ц-Ч
- Ш-С
- Ж-З
- Д-Т

